



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын хураангуй тайлан

Аудитын сэдэв: Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/100 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийж гүйцэтгэв

АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ: ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ЗОХИХ ҮР ДҮНГЭЭ ӨГСӨН БАЙНА

Аудитын тайланг хүргүүлсэн этгээд: Архангай аймаг дахь Төрийн аудитын газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга

Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: Aigulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: У.Ербол

Утас: 94159291 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Аудитор: Х.Манаргүл

Утас: 99425121 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuya.b@audit.gov.mn

Аудитор: Ж.Назгүл

Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn

Аудитор: Х.Еркебулан

Утас: 99999844 Цахим хаяг: erkebulankh@audit.gov.mn

Аудитор: С.Нурлан

Утас: 99103281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Аудитын харилцан хамаарал:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дагуу хийсэн.

Аймаг, сумын хэмжээнд ОНХС-ийн 2023 оны хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 11,595.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 722 төсөл арга хэмжээ байна. Үүнээс:

✓ Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 5,478.5 сая төгрөгийн 166 төсөл арга хэмжээ, сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 6,117.2 сая төгрөгийн 556 төсөл, арга хэмжээ байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон эсэх, зориулалтын дагуу зарцуулсан эсэх, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээ, үр дүнтэй, үр нөлөөтэй эсэх нь эрсдэлтэй гэж үзсэн нь аудит хийх гол шалтгаан юм.

Аудитын дүнг Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт хүргүүлснээр улсын хэмжээнд нэгтгэгдэж нэгдсэн дүн гарч, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын зорилго, зорилтууд, хамарсан хүрээ:

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж гарган, УИХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитын гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх

Аудитад аймаг, сумын ИТХ, Засаг дарга түүний харьяа Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Барилга захиалагчийн алба зэрэг холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан хамруулав.

Аудит хийхэд гарсан хүндрэл бэрхшээл: Талбарын ажлыг гүйцэтгэх үе шатанд аудитад шаардлагатай баримт материал бүрэн бус, холбогдох зарим албан тушаалтнууд амралтай байсан тул баримт, материал цуглуулахад хүндрэлтэй байсан.

Аудитын гол үр дүн:

1.1.1. ОНХНС-гаас Баян-Өлгий аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 10,073.8 сая төгрөгөөр баталсан байна

Монгол Улсын Их Хурлаас баталсан Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн 59.1-д заасны дагуу 2023 оны Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас Баян-Өлгий аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг анх 8,028.7 сая төгрөгөөр төлөвлөн баталсан ба 2023 оны Төсвийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтөөр Баян-Өлгий аймгийн Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 2,045.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 10,073.8 сая төгрөгөөр баталжээ.

1.1.3. Сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу олгоогүй байна

ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлгийг аймаг, сумын ОНХС-д дараах байдлаар хуваарилж олгосон байна.

Хүснэгт № 2 Аймаг, сумдын ОНХС-ийн санхүүжилт /сая төгрөгөөр/

№	Сум	ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлэг	Сумдад олгосон орлогын шилжүүлэг	Зөрүү
1	Алтай сум	320.5	315.5	-5.0
2	Алтанцөгц сум	162.4	162.4	0.0
3	Баяннуур сум	292.4	287.4	- 5.0
4	Бугат сум	141.0	141.0	0.0
5	Булган сум	576.8	560.8	-16.0
6	Буянт сум	159.0	154.0	-5.0
7	Дэлүүн сум	588.1	538.1	-50.0
8	Ногооннуур сум	601.5	586.5	-15.0
9	Сагсай сум	251.8	247.8	-4.0
10	Толбо сум	257.6	250.6	-7.0
11	Улаанхус сум	501.9	451.9	-50.0
12	Цэнгэл сум	567.2	517.2	-50.0
13	Өлгий сум	704.8	734.3	29.5
Сумын дүн		5,124.8	4,947.3	- 177.5
Аймгийн ОНХС		4,949.0	4,964.7	15.7
НИЙТ		10,073.8	9,912.0	-161.8

Эх сурвалж: Аймгийн ОНХС-гийн хуваарилалтад хийсэн аудитын судалгаа

Аудитын илрүүлэлт:

Аймаг, сумын ОНХС-ийн орлогын шилжүүлгийг 161.8 сая төгрөг дутуу олгосон нь ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн төлөвлөгөө дутуу хэрэгжсэнтэй холбоотой байна.

Дэлүүн, Улаанхус, Цэнгэл сумын ОНХС-д 50.0 сая, бусад сумдад 4.0-16.0 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгож, Өлгий сумын ОНХС-д 29.5 сая төгрөгийн, аймгийн ОНХС-д 15.7 сая төгрөгийн санхүүжилтийг илүү олгосон байна.

Аудитын дүнгээр сумуудад олгох ОНХС-ийн орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу олгож хууль тогтоомж, дүрэм, журмыг биелүүлж ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөмж болгов.

1.2.1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ТАХ-д урьдчилсан саналын жагсаалтыг боловсруулж, эрэмбэлээгүй, харин Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 84.3% нь эрэмбэлэгдсэн байна.

Аймаг, сумын хэмжээнд ОНХС-ийн 2023 оны хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 11,595.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 722 төсөл арга хэмжээ байна. Үүнээс:

✓ Аймгийн ОНХС: Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 5,478.5 сая төгрөгийн 166 төсөл арга хэмжээг баталсан боловч 10 хувь буюу 548.7 сая төгрөгийн 25 төсөл арга хэмжээ нь төлөвлөлтийн шатанд урьдчилсан саналын жагсаалтыг боловсруулж, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаагүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнд иргэдийн саналаар дэмжигдээгүй, чиг үүрэгт хамааралгүй төсөл арга хэмжээг төлөвлөхгүй байх, мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөмж болгов.

Сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 6,117.2 сая төгрөгийн 556 төсөл, арга хэмжээний 11.8 хувь буюу 927.1 сая төгрөгийн 66 төсөл, арга хэмжээ нь иргэдийн санал аваагүй, эрэмбэлэгдээгүй байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажилд давхардсан тоогоор 175,425 иргэнээс 51,435.6 сая төгрөгийн 1569 төсөл, арга хэмжээнд санал авч, 11,595.6 сая төгрөгийн 722 ТАХ-г баталсан ба 39,839.9 сая төгрөгийн 847 төсөл, арга хэмжээ цуцлагдсан байна. /Судалгаа-10/

Аудитын илрүүлэлт:

Алтай сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 48.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6, Алтанцөгц сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 56.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, Булган сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 106.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, Бугат сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 32.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2, Цагааннуур сумын 50.0 сая төгрөгийн 9, Өлгий сумын 538.5 сая төгрөгийн өртөгтэй 42, Дэлүүн сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 95.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээ иргэдийн санал аваагүй, эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээ байна

Аудитаар иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээ баталсан зөрчлийг таслан зогсоох, Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар

баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг баримтлан ажиллах албан шаардлагыг аймаг, сумын Засаг дарга нарт хүргүүлэв.

1.2.4.Аймгийн ОНХС-гаас чиг үүрэгт хамааралгүй 890.9 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг тусгасан байна

"Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.2¹-д найман чиг үүргийн хүрээнд барилга байгууламж барих, тоног төхөөрөмж худалдан авах, их засвар хийх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр журамласан байна.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамааралгүй, иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй нийтдээ 548.7 сая төгрөгийн 25 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн зөрчилд зөрчил арилгах албан шаардлага өгөв.Үүнд:
- Бүсчилсэн хөгжлийн хүрээнд форум зохион байгуулах зардал, Гадаад болон дотоод хөрөнгө оруулалтыг татах форум зохион байгуулах зардал 110.0 сая төгрөг
- Өлгий сумын 11 дүгээр багийн нийтийн орон сууцны засварын ажил 30.0 сая төгрөг
- Төрийн үйлчилгээний цогцолборын хурлын заал, E-mongolia Төрийн үйлчилгээний төвийн тоног төхөөрөмж, хатуу эдлэл 106.0 сая төгрөг
- Эмчилгээний зардал 0.8 сая төгрөг
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, терроризмтай тэмцэх үйл ажиллагааны зардал 15.0 сая төгрөг
- Нүүдэлчин Монгол-2023 их наадмын зардал 15.0 сая төгрөг
- Төрийн албаны Салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардлаас өмгөөлөгчийн хөлс 3.0 сая төгрөг, хоолны зардал 7.0 сая төгрөг
- Сагсай, Бугат сумын Ахмадын өрөөний тоног төхөөрөмж, хатуу эдлэл худалдан авах 36.5 сая төгрөг
- Дулааны тоолуур нийлүүлэх ажил нийт зардал 37.1 сая төгрөг
- Онцгой байдлын газрын сургалт, бэлтгэлийн танхимын засвар, тохижилт, шалган нэвтрүүлэх байрны барилгын ажил 33.45 сая төгрөг
- Улаанхус суманд ХЦ-ийн 285 дугаар ангид хилийн тор татах ажил, ХЦ-ийн 165, 285 дураар ангиуудад тоног төхөөрөмж худалдан авах, ХЦ-ийн 285 дугаар ангид харуулын байр, шалган нэвтрүүлэх кабин худалдаж авах 63.3 сая төгрөг
- Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэст тоног төхөөрөмж худалдан авах 20.0 сая төгрөг
- Аймгийн Прокурорын байрны засвар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тохижилт, Дэлүүн сумын цагдаагийн байранд хашаа татах 26.0 сая төгрөг,
- зочин хүлээн авах зардал 20.0 сая төгрөг

ОНХС-ийн журмын 4.4²-т өсөн чиг үүргийг, 4.5³-т малын тоо толгойн татвараас 12 чиг үүргийг хэрэгжүүлэхээр журамласан байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 6,117.2 сая төгрөгийн 556 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс ОНХС-ийн чиг үүрэг хамааралгүй 150.4 сая төгрөгийн 15

төсөл арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна. Үүнд: Баяннуур, Дэлүүн сум тус бүр 1, Булган, Толбо, Цагааннуур тус бүр 3, Өлгий сум 4 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Аудитын дүнгээр сумын Засаг дарга нарт ОНХС-ийн чиг үүрэгт хамааралгүй, иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

2.1.2. ОНХС-ийн хөрөнгийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож, зориулалтын дагуу зарцуулсан байна

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд нийт 11,595.6 сая төгрөгийн 722 төсөл арга хэмжээ төлөвлөснөөс 82.8 хувь буюу 8,547.8 сая төгрөгийн 598 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 427.5 сая төгрөгийн 33 төсөл, арга хэмжээ хэрэгжих шатанд 2,260.3 сая төгрөгийн 91 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Хүснэгт №5 ТАХ-ний хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Аймаг, нийслэл, сум, дүүрэг	ИТХ-аар батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Бүрэн хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний				Дутуу хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний			Огт хэрэгжээгүй ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний	
	тоо	дүн	тоо	Гэрээний дүн	Үүнээс дутуу олгосон санхүүжилт		тоо	Гэрээний дүн	Олгосон санхүүжилт	тоо	дүн
					тоо	дүн					
2	3	4	7	8	9	10	11	12	13	14	15
Алтай сум	30	352.0	29	337.0	-	-	1	15.0	9.3	-	-
Алтанцөгц сум	18	190.7	11	141.3	-	-	1	4.9	-	6	44.5
Баяннуур сум	27	451.8	11	261.4	-	-	-	-	-	16	170.5
Бугат сум	26	156.5	23	134.5	-	0.9	-	-	-	3	22.0
Булган сум	59	650.0	58	559.0	-	-	-	-	-	1	91.0
Буянт сум	24	245.5	17	143.2	-	-	3	37.3	14.0	4	64.9
Дэлүүн сум	69	632.1	44	470.8	-	-	9	88.0	50.5	16	73.3
Толбо сум	50	401.7	44	325.0	-	-	3	20.5	16.6	3	56.2
Ногооннуур сум	57	589.8	53	549.3	-	-	-	-	-	4	40.5
Сагсай сум	12	261.9	11	246.9	-	-	1	15.0	11.0	-	-
Улаанхус сум	63	535.5	52	268.5	-	-	8	129.0	68.7	3	138.0
Цэнгэл сум	48	825.0	32	490.0	-	-	5	50.9	29.4	11	284.1
Цагааннуур тосгон	15	86.5	15	85.5	-	1.0	-	-	-	-	-
Өлгий сум	58	738.0	55	711.6	-	1.5	-	-	-	3	26.5
сумын дүн	556	6,117.6	455	4,745.0	-	3.4	31	360.6	199.4	70	1,011.5

Аймгийн ОНХС	166	5,478.5	143	3,802.8	4	73.4	2	66.9	41.3	21	1,608.7
нийт дүн	722	11,595.6	598	8,547.8	5	76.8	33	427.5	240.7	91	2,260.3

Эх сурвалж: ТАХ-ний хэрэгжилтэд хийсэн аудитын судалгаа

Аймаг, сумын ОНХС-аас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч хэрэгжээгүй төсөл арга хэмжээ нь зураг төсөвт магадлал хийгдээгүй, зураг, төсөв хүлээлгэж өгөөгүй, хэд хэдэн удаа тендер зарлагдсан боловч гүйцэтгэгч нь сонирхоогүй, тендерийн маргаанаас болж гүйцэтгэгч нь жилийн эцэст шалгарсан, ТАХ-г хэрэгжүүлэх байгууллага өөрөө татгалзсан, хэрэгжээгүй, мөнгө нь хүрээгүй зэргээс шалтгаалсан байна.

ОНХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу бодит гүйцэтгэлд үндэслэн, зориулалтын дагуу зарцуулсан боловч дараах зөрчлүүд илэрсэн.

Аудитын илрүүлэлт:

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр “Еба констракшн” ХХК хийж гүйцэтгэсэн 34.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Булган сумын цэцэрлэгийн дээврийн засварын ажлыг дуусгасан гэх боловч ажлын хэсэг томилоогүй, гэрээ дүгнээгүй, барилга, байгууламжийг ашиглалтад хүлээж аваагүй,
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Баяннуур сумын Цэцэгт багийн бага сургуулийн 249.9 сая төгрөгийн гэрээний дүнтэй өргөтгөлийн ажлыг хүлээж авах комисс нь ашиглалтад аваагүй байна.
- Буянт сумын ОНХС гамшгийн зардалд баталсан 3.0 сая төгрөгийг бүрдэл дутуу баримтаар зориулалтын бус зарцуулсан.
-

Аудитын дүнгээр зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах талаар албан шаардлага өгөв.

2.2.1. ОНХС-ийн төлөвлөсөн төсөл арга хэмжээний 98.6 хувь нь хэрэгжсэн байна

Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд бүрэн хэрэгжсэн 8,547.8 сая төгрөгийн 597 төсөл, арга хэмжээний 98.3 хувь нь буюу 8,431.8 сая төгрөгийн 587 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтод түвшинд хүрсэн байна.

Харин 116.0 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээ төлөвлөсөн зорилтот түвшин, үр дүнд хүрээгүй байна. Аудитын дүнгээр төлөвлөсөн зорилтот үр дүн, үр ашигт хүрээгүй дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын илрүүлэлт:

Толбо сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 3 багт 100.0 сая төгрөгийн өртөгтэй гүний худаг гаргах ажил нь ашиглалтад ороогүй байгаа нь хөрөнгө оруулалтын зорилгод нийцээгүй, үр ашиггүй хөрөнгө оруулалт болсон.

Улаанхус сумын Хөх хөтөл багт ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 6.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цэцэрлэгийн складын байр барих, Согоог голд 10.0 сая төгрөгийн мал дамжин өнгөрөх гүүр шинээр барих ажил чанаргүй баригдсанаас ашиглах боломжгүй байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгийн зориулалтын дагуу ашиглах, үр ашгийг дээшлүүлэхийг сумдын Засаг даргад албан шаардлагыг хүргүүллээ.

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалт орон нутгийн хөгжил зохиох хувь нэмрээ оруулсан байна

Орон нутгийн хөгжилд хувь нэмэр өгөхүйц бодит үр дүнтэй ажил болсон төсөл, арга хэмжээнүүдийн заримаас дурдвал:

- Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр Алтай сумын төвд 58.0 сая төгрөгөөр гэрэлтүүлэг ашиглалт орсноор сумын ард иргэдийн аюулгүй, тав тухтай амьдрах орчин бүрдсэн.
- Ногооннуур сумын төвд 22.3 сая төгрөгөөр хүүхэд залуучуудын тоглоомын талбай ашиглалтад орсноор хүүхэд, залуучууд чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, спортоор хичээллэх орчин бүрдсэн, 20.0 сая төгрөгөөр трансформатор тавьснаар 40 өрх цахилгаанаар хангагдаж, жижиг дунд үйлдвэр явуулах боломж бүрдсэн.
- Тус сумын Ямаат 5 дугаар багт 27.0 сая төгрөгөөр гүний худаг ашиглалтад орсноор 15-20 өрх ундны усаар хангагдаж, 24.5 сая төгрөгөөр сүлжээ оруулснаар Морин толгой, Ямаат, Хос харагай, Чихтэй, Цагааннуур багуудын иргэд үүрэн холбоо, 4 сүлжээ ашиглах боломж бүрдсэн.
- **Өлгий сумын ОНХС-гийн хөрөнгөөр бодит үр дүнгээ өгсөн төсөл арга хэмжээнүүдийн заримаас нь дурдвал:**
- 2, 4, 8, 10, 11, 13 дугаар багуудад нарны цэнэгтэй гэрэлтүүлэг тавих 136.0 сая төгрөгийн 9 арга хэмжээний үр дүнд иргэдийн аюулгүй амьдрах орчин сайжирсан.
- 2, 3, 8, 11, 13 дугаар багуудын хилийн заагт буюу 4 замын гэрлэн дохио шинээр тавих 3 ажлын үр дүнд замын хөдөлгөөнд зөв зохистой оролцох нөхцөл бүрдсэн.
- Ерөнхий боловсролын 1 бага сургууль, 2 цэцэрлэгийн барилга шинээр баригдаж, 18 сургууль, цэцэрлэгийн засвар, хүүхдийн тоглоомын 10 талбай ашиглалтад орж, шинээр баригдсан хүүхдийн цэцэрлэгүүдийг 83.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, хатуу зөөлөн эдлэлээр хангаснаар сургууль, цэцэрлэгийн хүүхдийн сурах орчин, нөхцөл сайжирсан.

3.1.2. Төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлсэн байна

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн 1,593.0 сая төгрөгийн 55 төсөл арга хэмжээний захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлж, иргэний болон авто замын барилгын ажлын үе шатанд график төлөвлөгөөний дагуу хяналт хэрэгжүүлж зураг төсөв технологийн дагуу гүйцэтгүүлж, барилгын материалын чанар, аюулгүй байдал, холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, БНБД, журмыг мөрдүүлэн, бичиг баримтыг бүрдүүлэлтийг хангуулан ажиллажээ.

- ✓ Шилжих хөрөнгө оруулалтаар 8 төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хийж 100% гүйцэтгэлтэйгээр байнгын ашиглалтад оруулсан байна.
- ✓ Барилга угсралт, засварын 15, гудамж талбайд гэрэлтүүлэг тавих 5, авто замын засварын 5, цахилгаан татах 10, худаг гаргах 4 төсөл арга хэмжээ зэрэгт тус тус хяналт тавьж ажилласан байна.

Сумуудын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн нийтдээ 476 төсөл арга хэмжээнд гэрээ хийсэн захиалагч байгууллагууд тухай бүр хяналт хийж гэрээнд заасан шаардлын дагуу сумын Засаг даргын захирамжаар байгуулсан ажлын хэсэг хүлээж авсан байна.

3.2.2. ОНХС-гийн хөрөнгөөр бий болсон 552.8 сая төгрөгийн хөрөнгийг орлого аваагүй байна

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг зарим ашиглагч байгууллагууд орлого авч бүртгэл тайланд тусгаагүй байна.Үүнд:

Алтай сумын Тэжээлийн нөөц бүрдүүлэх 31.0, Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд чөлөөт бөхийн дэвжээ авах 16.0, ЗДТГ-ын зуухын байр шинээр барих 17.0, Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийг камержуулах ажил 3.0.0, Сагсай сумын төвд хүүхдийн тоглоомын талбай 15.1, ЗДТГ-ын өргөтгөлийн байр 266.5, Өлгий сумын гүүний худаг 30.8, тэжээлийн нөөц бүрдүүлэх 24.5, тэрбум мод 16.9, Өлгий сумын гудамжны гэрэлтүүлэг 58.6, Онцгой байдлын газрын сургалт, бэлтгэлийн танхимын засвар, тохижилт 15.0 Өлгий сумын 11 дүгээр багт гэрэлтүүлэг 18.9, Өлгий сумын 13 дугаар баг, Толбонуур гудамж 26-2600 тоот гүний худаг 19.8, аймаг дахь төрийн цахим үйлчилгээний хэлтсийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж 19.8 сая зэрэг нийтдээ 552.8 сая төгрөгийн хөрөнгийг ажлын хэсэг хүлээн авсан боловч орлогод авч данс бүртгэлд тусгаагүй байгааг ашиглагч байгууллагуудын орлого авч бүртгэл тайланд тусгаж, зөрчлийг арилгах талаар холбогдох байгууллагуудад албан шаардлага өгөв.

3.2.3. ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд 8 сум мэдээллийг оруулаагүй байна

Аймгийн ОНХС-ан болон Алтай, Алтанцөгц, Баяннуур, Дэлүүн, Сагсай, Өлгий сумууд орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналаа ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд бүрэн оруулсан байна.

Бугат, Булган, Буянт, Толбо, Улаанхус, Цэнгэл сум, Цагааннуур тосгоны Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлагын мэдээллийн санд оруулах мэдээллийг огт оруулаагүй өмнөх гарсан зөрчлийг давтан гаргасан 7 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага, Ногооннуур сумд зөрчил арилгах албан шаардлага өгөв.

Аудитын дүнгээр аймаг, сумын ОНХС-гуудад нийт 2436.2 сая төгрөгийн зөрчил арилгуулах 20 албан шаардлага өгөгдлөө.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журмын төлөвлөсөн боловч сумуудын санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу олгоогүй байна.
2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээг эрэмбэлээгүй, нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулаагүй байна.
3. ОНХС-гаас иргэдийн саналаар дэмжигдээгүй, чиг үүрэгт хамааралгүй төсөл, арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн байна.
4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний зохих үр дүн гарч, орон нутгийн хөгжил зохих хувь нэмрээ оруулсан байна
5. Төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хууль, журмын дагуу хэрэгжүүлсэн байна
6. ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд 8 сум мэдээллийг огт оруулаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I. Аймгийн Засаг дарга /А.Камелият/-д:

- 1.Сумдын ОНХС-гийн орлогын шилжүүлгийг баталсан хуваарийн дагуу олгож байх.
- 2.Аймгийн ОНХС-гаас иргэдийн саналаар дэмжигдээгүй, чиг үүрэгт хамааралгүй төсөл арга хэмжээг төлөвлөхгүй байх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5-т заасан хугацаанд буюу аудитын тайланг хүлээн авснаас 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.